

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хот байгуулалтын тухай хуулийг анх 1998 онд батлан мөрдүүлж, хот байгуулалтын салбарын хөгжлийн чиг хандлагад үүссэн цаг үеийн шаардлагаар уг хуулийг 2008 онд шинэчлэн найруулж, нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Энэ хууль хэдийгээр тухайн цаг үеийн хөгжлийн шаардлагыг хангаж байсан боловч өнөөгийн нийгмийн хөгжилд нийцэхгүй, хэрэгцээ, шаардлагыг тэр бүр хангахгүй болжээ. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан Хот байгуулалтын тухай хуулийг бусад хууль тогтоомж, эрх зүйн акттай уялдуулах ажлын хүрээнд уг хуулийн хийдэл, давхардал, зөрчлийн судалгаа хийгдэж, уг хуультай холбоотой нийт 56 давхардал, хийдэл, зөрчил байна гэсэн дүгнэлт гарсан байна.

Сүүлийн 20 гаруй жил хотжих үйл явц эрчимтэй явагдаж, хөдөөнөөс хот, суурин газрыг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хотжилтын төвшин хурдацтай нэмэгдэж 67.6 хувьд хүрээд байна. Тухайлбал, нийслэл, бүсийн тулгуур төв болон аймгийн төв болох 23 хотод манай улсын нийт хүн амын 60 гаруй хувь нь оршин сууж, ажил, хөдөлмөр, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа. Үүнээс зөвхөн Улаанбаатар хотод оршин суугчдын тоо 1 сая 800 мянгад хүрч, аж ахуйн нэгж, байгууллагуудын 70 орчим хувь нь байршиж, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна. Мөн Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг томоохон хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрлийн улмаас дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд зэрэг иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний даац хэтэрч, хүртээмж хүрэлцэхгүй байгаагаас нийгэм, эдийн засгийн олон асуудал тулгамдаад байна.

Иймээс төвлөрлийг сааруулахын тулд орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотуудыг дэмжин байгуулах замаар хүн амын тогтвортой хөгжил бүхий нутагшилт, суурьшлын бодлогыг шинээр боловсруулан хэрэгжүүлэх шаардлага бий болсон. Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлэх зорилго бүхий Улаанбаатар хот-"20 минутын хот" стандарт, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дагуул хот, шинэ суурьшлын бүс байгуулах зорилт тусгагдсаны дагуу Хөшигийн хөндийн шинэ суурьшлын бүс, Орхоны хөндийд хот байгуулах зэрэг ажлуудыг эхлүүлээд байна.

Шинэ хот төлөвлөлт хийхэд бүс байгуулах хот төлөвлөлтийг хийхэд иргэдийг эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрахад, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг оновчтой тооцож төлөвлөхөд чиглэсэн эрх зүйн орчныг шинэчлэн

бүрдүүлэх, хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч, хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, хот байгуулалтын мэргэжлийн байгууллагын чиг үүргийг тодорхой болгож сайжруулах, хот, суурин газрын төлөвлөлт, хэрэгжилтийг хангахтай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж хоорондын харилцан уялдааг хангах зорилгоор хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төслүүдтэй хамт боловсруулах шаардлагатай байна. Иймд дээрх шаардлагад үндэслэн:

1. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл,
2. Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,
3. Хот суурин газрын дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл,
4. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,
5. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг хамт боловсруулж хот төлөвлөлт, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжтэй холбоотойгоор тулгамдаж буй дээрх асуудлыг шийдвэрлэх, хууль хоорондын нийцлийг хангах зохицуулалтуудыг тусгалаа.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ